



Сургуулиас түр чөлөөлөх эсвэл хөөх шийдвэрийг давж заалдах тухай

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Давж заалдах гэж юу вэ?

Давж заалдах гэдэг нь аливаа шийдвэрийг дахин нягтлахыг хүссэн хүсэлт юм. Энэ нь та тухайн гаргасан шийдвэрт сэтгэл хангалуун бус байгааг илэрхийлнэ.

Сургуулиас түр чөлөөлөх эсвэл хөөх шийдвэрийг би хэрхэн давж заалдах вэ?

Хэрвээ та сургуулийн захирлыг, холбогдох журам зөрчсөн, эсвэл шударга бус шийдвэр гаргасан хэмээн үзвэл сурагчийг түр чөлөөлөх эсвэл хөөх тус шийдвэрийг давж заалдаж болно. Ингэхдээ сурагч, эцэг эх эсвэл асран хамгаалагч [давж заалдах маяг](#)тыг бөглөнө.

Давж заалдах өргөдөл гаргахдаа харьяа [Боловсролын Хэлтэс](#)-т хандана. Харьяа Боловсролын хэлтэс нь танд тухайн үйл явцыг сайн ойлгож авахад туслах болно. Мөн давж заалдах өргөдөл бичихэд тань тэд туслах боломжтой. Та харьяа Боловсролын Хэлтсийн холбоо барих мэдээллийг хүүхдийнхээ сургуулиас авч болно.

Шийдвэр бүрт зөвхөн нэг давж заалдах өргөдөл гаргана. Давж заалдах өргөдлийн шийдвэрийг Боловсролын манлайлал хариуцсан Захирал эсвэл Сургуулийн гүйцэтгэл хариуцсан гүйцэтгэх Захирал гаргах ба хичээлийн 15-20 өдөрт багтаан шийдвэрлэнэ. Давж заалдах өргөдөл хүлээн авсан, мөн шийдвэр гарсан үед энэ талаар тантай холбогдох болно. Хэрвээ танд нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол давж заалдах өргөдөл гаргахдаа хандсан харьяа Боловсролын Хэлтэстэйгээ холбогдоорой.

Сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг давж заалдсан өргөдлийн үр дүн

Хэрвээ сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг давж заалдсан өргөдөл дэмжигдэн, шийдвэр гаргагч таны хүсэлттэй санал нэгдэж байвал таны хүүхдийг аль болох хурдан сургуульд буцаан оруулахын тулд тзахирал тантай холбогдох болно. Давж заалдах өргөдлийн шийдвэр таны хүүхдийн бүртгэлд тэмдэглэгдэх ба сургуулиас түр чөлөөлөх шийдвэр таны хүүхдийн бүртгэлээс хасагдах болно.

Хэрвээ сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг давж заалдсан өргөдөл дэмжигдэхгүй, шийдвэр гаргагч таны хүсэлттэй санал нэгдэхгүй байвал таны хүүхэд тухайн заасан он сар өдөр хүртэл сургуулиас түр чөлөөлөгдсөн хэвээр байх болно.

Сургуулиас хөөх шийдвэрийг давж заалдсан өргөдлийн үр дүн

Хэрвээ сургуулиас хөөх шийдвэрийг давж заалдсан өргөдөл дэмжигдэн, шийдвэр гаргагч таны хүсэлттэй санал нэг байвал сургуулийн захирал аюулгүй байдалтай холбоотой ноцтой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор тантай хамтран ажиллаж болно. Мөн сурагчийг сургуульдаа буцаж ороход нь шаардлагатай дэмжих арга хэмжээг авснаар таны хүүхэд сургуульдаа буцан орох боломжтой болно. Давж заалдах өргөдөл дээр гаргасан шийдвэр таны хүүхдийн бүртгэлд тэмдэглэгдэх ба сургуулиас хөөх шийдвэрийг уг бүртгэлээс хасах болно.

Хэрвээ сургуулиас хөөх шийдвэрийг давж заалдсан өргөдөлтэй шийдвэр гаргагч санал нэгдэхгүй тохиолдолд таны хүүхдэд бусад боломжууд нээлттэй байж болох юм. Зарим тохиолдолд таны хүүхдийг өөр сургуульд элсүүлэх, эсвэл хэрэгцээнд нь тохирсон зохион байгуулалт бүхий орчинд шилжүүлэх шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд сургуулийн захирал тантай хамтран ажиллах болно.

Хэрвээ сургуулиас хөөх шийдвэрийг давж заалдсан өргөдөл амжилтгүй болсон бөгөөд таны хүүхэд 17-оос дээш настай бол та болон таны хүүхэд үргэлжлүүлэн суралцах юм уу ажил хийх боломжийг харгалзан үзвэл зохино.

Би хэрхэн гомдол гаргах вэ?

[Хүүхдийнхээ эрх ашгийг өмгөөлөх](#) талаарх мэдээллийг эцэг эхчүүд авах боломжтой. Мөн сургуулиас түр чөлөөлөх, хөөх шийдвэрийг давж заалдах явцын талаар [гомдол гаргах тухай мэдээллийг](#) эцэг эхчүүд авах боломжтой юм.

Сургуультай хэрхэн харилцах тухай мэдээллийг [Сургуулийн Хүрээлэлд Баримтлах Дүрэм](#)-с авах боломжтой.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.